

### **3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:**

*а. “БиДиСек” ХК-ийн энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦТТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд эхний нийлүүлэлтийг ҮЦТТТХТ ХХК-ийн 07-999998 данснаас 900 000 ширхэгийг 3000 төгрөгийн үнэтэйгээр нийлүүлнэ.*

*Давуу эрхээр хувьцаа эзэмших хувьцаа эзэмшигчдийн хувьцааг арилжааны эхний өдрийн арилжаанаас өмнөх 10 минутанд байршуулах бөгөөд үлдсэн захиалыг үнийн ахлах дарааллаар гүйцэтгэнэ.*

**б.** *Үнэт цаасны арилжааны мэдээг Монголын хөрөнгийн биржийн ([www.mse.mn](http://www.mse.mn)) веб сайт, БиДиСек ХК-ийн ([www.bdsec.mn](http://www.bdsec.mn)) вэб сайт болон өөрийн харьяа брокер, дилерийн компаниудаас авч болно.*

- a. *“БиДиСек” ХК нь 2006.06.23-ны өдөр өөрийн компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10 000 000 ширхэг энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалж нээлттэй хувьцаат компани болсон.*

**5. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо:**

- a. 1,250,000,000 төгрөгийг компани өөрийн байртай болох зорилгоор үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийнэ.
- b. Тус байрны нийт өртөг нь 1,950,000,000 төгрөг бөгөөд үүнээс одоогийн байдлаар 700,000,000 төгрөгийн төлбөрийг 2007 оны ашгаас төлсөн байгаа.
- c. 250,000,000 төгрөгийг байрны засвар тохижуулалт, техник технологийн шинэчлэлд
- d. 1,500,000,000 төгрөгийг хөрөнгө оруулалт нэмэгдүүлэхэд
- e. 2008-2013 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөг хавсаргав.

**6. Үнэт цаасыг арилжаалахад санал болгох хүрээ:**

- a. *КТХ-ийн 39-р зүйлийн дагуу компанийн хуучин хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг олгон санал болгоно.*
- b. *Үлдэх хэсгийг олон нийтэд санал болгоно.*